

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/154/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2026 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ужиг Алтай Аудит ХХК-ны Захирал: Г.Ганболд
	Утас: 99117121 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НОГООННУУР
СУМЫН ХҮҮХДИЙН НЭГДҮҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т.БАХЫТГҮЛ ТАНАА

2026 02 25 № 176
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын хүүхдийн нэгдүүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын хүүхдийн нэгдүүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын хүүхдийн нэгдүүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлох үйл явдал гараагүй байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

832605000138

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЖАЙГУЛ

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,472,998,100.00	1,454,625,139.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,472,998,100.00	1,454,625,139.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,472,998,100.00	1,454,625,139.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,164,690,500.00	1,161,788,032.60
210101	Үндсэн цалин	701,359,100.00	698,721,203.00
210102	Нэмэгдэл	430,321,600.00	398,487,428.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт		33,290,900.70
210104	Урамшуулал	33,009,800.00	31,288,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,440,100.00	135,415,507.22
210201	Тэтгэврийн даатгал	97,950,900.00	90,927,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,622,300.00	11,491,507.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,811,200.00	5,811,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,811,200.00	5,811,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,244,500.00	21,374,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,826,000.00	19,826,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,480,000.00	4,480,000.00
210302	Түлш, халаалт	14,346,000.00	14,346,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	93,366,100.00	86,955,200.00
210502	Хоол, хүнс	93,366,100.00	86,955,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,000,000.00	16,000,000.00
210604	Урсгал засвар	16,000,000.00	16,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,612,100.00	4,612,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,612,100.00	4,612,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,063,300.00	30,028,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,172,000.00	22,137,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,891,300.00	7,891,300.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,472,998,100.00	1,363,144,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,437,172,100.00	1,327,318,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,437,172,100.00	1,327,318,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,826,000.00	35,826,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	35,826,000.00	35,826,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		115,524,689.08
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		24,043,949.26
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	48.00	48.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	26.00	26.00
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 1489.4 сая төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад 1489.4 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан. *Залруулсан алдаа*

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт улсын төсвөөс санхүүжих 1,437.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүжих 35.8 сая төгрөг, нийт 1,472.9 сая төгрөгийн төлөвлөгөөг тусгалгүйгээр алдаатай тайлагнасан байна.
- Мөнгөн гүйлгээний тайланд 16.4 сая төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тусган харуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар санхүүгийн тайлангийн аудитын асуудалтай холбоотой 0.4 сая төгрөгийн зөрчил¹ илэрч, 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайланд онд нэг албан хаагчд олгосон 0.4 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр баргадуулах акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТГТайланг зөрүүтэй тайлагнасан	1	1,472,998.1	1	1,472,998.1			1	1,472,998.1				
Мөнгөн гүйлгээний тайланд биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тусган харуулаагүй байна.	1	16,477.0			1	16,477.0	1	16,477.0				
Дүн	2	1,489,475.1	1	1,489,478.1	1	16,477.0	2	1,489,475.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй орхигдуулсан	1	400.0	1	400.0									
Дүн	1	400.0	1	400.0									

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												

Ногооннуур сумын хүүхдийн нэгдүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн								
Нийт дүн								